# ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**2023.11.30.**

| № | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ,сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжит хэлбэрээр нийгмийн даатгалын албан хаагчид болон олон нийтэд сурталчилж байх. | - Баримтжуулсан байх<br>- Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) | Авлигатай тэмцэх газрын хамтран ажиллах тухай 03/9047 тоотын дагуу **“Шүгэл”** ажиллагааны хүрээнд бэлтгэсэн постерийг байгууллагын сайт, фейсбүүк хуудсанд 2 постер байршуулан тус аянд нэгдсэн бөгөөд 40 албан хаагч, байцаагчид шэйр хийж олон нийтэд түгээж 5000 гаруй хандалт авсан.<br>Мөн хэлтсийн байранд соён гэгээрүүлэх аяны зурагт хуудсыг байршуулан албан хаагч болон олон нийтэд сурталчлан ажиллаж байна.<br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 1.2.Авлигын эсрэг нөлөөлийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах: | - 2-оос доошгүй өдөрлөг, нөлөөлийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх:<br>- Үр дүнг тооцож нотломжийг хавсаргасан байх | - 2023 оны 05 дугаар сарын 26-нд аймгийн ахмадын хороотой хамтран Биеийн тамир спортын зааланд аймгийн нийт ахмадуудын дунд өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгөөр **“Нийгмийн даатгалын 2022 он болон 2023 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан”**-г танилцуулж, сонирхсон асуултанд хариулж, ахмадуудын санал хүсэлтийг сонсож, ярилцлага зохион байгуулсан ба өдөрлөгт нийт **170** гаруй ахмад оролцсон.<br> <br>- Аймгийн ИТХурлын 01 тогтоолоор Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, шийдвэр гаргах түвшинд иргэдийн санал санаачлагыг тусгах, төрийн үйлчилгээг иргэд байгууллагад нээлттэй ил тод хүргэх, ажлын уялдааг хангах, тайлагнах зорилгоор “Иргэдийн өдөр”-ийг жил бүрийн 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж байхаар тогтсон. Энэ арга хэмжээнд манай байгууллага идэвхтэй оролцож байгууллагынхаа үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан танилцуулж мөн сургалт сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээг хүргэн ажилласан. Өдөрлөгт 20 сум 2 тосгоны 100 гаруй иргэд оролцсон.<br>  |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | |   |
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд" мэдээллийн самбарын мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол ажиллуулах; | - Мэдээллийг сар бүр шинэчлэх;<br>-Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх. | **"Шударга ёс, хөгжил дэвшилд"** самбарыг тогтмол ажиллуулж сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг 11 удаа, 3 удаа сул орон тооны мэдээлэлийг тус бүр шинэчиэн мэдээлж мөн санал хүсэлт, өргөдөл гомдлын хайрцагыг байнга байршуулж байна.   |
| 2 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтанд хамруулах | 2.1 Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон нийт албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх; | - Шинэ томилогдсон болон нийт албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | **Нийтдээ 7 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 115 албан хаагч хамрагдсан.**<br>- Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинар сургалтанд албан хаагчдыг тогтмол хамруулж байна. Үүнд: 2023-02-02 **“Авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал”** сургалт 14 албан хаагч хамрагдсан.<br>- **“ Авлига, ашиг сонирхолын зөрчил”** сэдвээр 2023-03-16-нд Хэнтий аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Б.Буяндэлгэр, ахлах прокурор М.Отгонбаатар нар танхимаар 37 албан хаагч хамрагдсан.<br>- “Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалт 2023-03-29нд НДЕГ-с зохион байгуулсан бөгөөд 3 албан хаагч хамрагдсан.<br>- Төрийн байгууллагын алба хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шинээр болон |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийн талаар АЗДТГазар мэдээлэл өглөө. 12 албан хаагч хамрагдлаа.<br>- 2023-06-02нд “Төрийн албан хаагчийн ёс зүй”- сургалт АЗДТГ, ТАЗ-с танхимаар зохион байгуулсан. Хамрагдсан албан хаагч 10<br>- Орон нутагт нийтлэг гарч буй авлига, ашиг сонирхлын зөрчилд анхаарах асуудалын талаар АЗДТГ-с 2023.06.15нд сургалт хийж 4 албан хаагч хамрагдсан.<br>- Төрийн албаны ёс зүйн тухай хууль<br>- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь<br>- Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчийн харилцаа ба хандлага, кэйсүүд 2023.10.16нд НДЕГ-ын ТГ-ын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Мө.Гэрэлмаа танхимаар явуулж 35 албан хаагч хамрагдсан. |
| | | 2.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | Нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | • Төрийн үйлчилгээний албан хаагчийн авлигаас урьдчилан сэргийлэх, харилцаа хандлага, үйлчилгээний чанарыг үнэлэх төхөөрөмж, үйлчлүүлж буй иргэдийн бичлэг хийх ширээний камер, бичлэгийн төхөөрөмжийг АЗДТГазрын хөрөнгөөр үйлчилгээний заалны 7 байцаагчдад суурилуулж 2022 оноос эхлэн тогтмол ажиллуулж үйлчилгээ авсан иргэд даатгуулагчаар үнэлгээ даруулан ажиллаж байна. Үнэлгээний нэгтгэлийг сар бүрийн 25-нд аймгийн ЗДТГ-ын Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэн ажилдаг.<br>**Оны эхнээс: 300 иргэд, даатгуулагч үйлчлүүлсний:**<br>- **259 буюу 86.3 хувь нь маш сайн,**<br>- **37 буюу 12.3 хувь нь сайн ,**<br>- **2 буюу 0,7 хувь дунд,**<br>- **2 буюу 0,7 хувь муу гэж үнэлсэн.**<br>Үнэлгээний төхөөрөмж ажиллуулж эхэлсэнээр даатгуулагч, байцаагчдын хооронд ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой өргөдөл, гомдол ирээгүй болно.<br>• Тайлант хугацаанд 5,10 дугаар сард Сэтгэл ханамжийн судалгааг иргэд даатгуулагчдаас цахимаар авсан ба нийт **585** даатгуулагч хамрагдсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | |     |
| 3 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1. Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах; | - Байгууллагын албан ёсны цахим хуудас. нийгмийн сүлжээнд тухай бүр байршуулсайн байх | -www.hentii.ndaatgal.mnвэбсайт, facebook.com/NDKHenti фэйсбүүкээр, “Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс“ фэйж хуудсаар 35 мэдээлэл, постер оруулж мөн ХНХЯам, НДЕГазраас бэлтгэсэн 25 төрлийн сурталчилгаа, мэдээ, мэдээллийг цахим сүлжээ ашиглан олон нийтэд хүргэсэн ба давхардсан тоогоор 60 мянга гаруй иргэд даатгуулагчдад хүрсэн байна.<br>“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг баримтлан байгууллагын батлагдсан төсөв, Нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэл болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл, аудитын дүгнэлт, өндөр дүнтэй зарлагын мөнгөн гүйлгээ гэх нийт 20 мэдээлэл, 178 шийдвэрийг хугацаанд нь мэдээлж байршуулан ажилласан байна.<br>Мөн НДЕГ-с ирүүлсэн 2023 оны 05 дугаар сарын 23-ны 01/1132 тоот Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан бичгийн дагуу:<br>- Нийгмийн даатгалын хэлтсийн вебсайтад иргэд, даатгуулагч, ажил олгогчдын мэдэээлэл авах боломжийг бүрдүүлсэн<br>- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан Нийгмийн даатгалын чиг үүрэгт хамаарах 1 дүгээр хавсралтад заагдсан мэдээллийг цахим хуудсандаа бүрэн байршуулсан<br>- 2-р хавсралтад заагдсан мэдээллийг хэлтсийн мэдээллийн самбар болон шударга ёс, хөгжил дэвшилд самбарт байршуулсан. |
| 4 | Байгууллагын удирдлагын авлигатай | 4.1. Авлигатай тэмцэх “Шуур’ ажиллагааны хүрээнд Засгийн газрын | Чиглэлийг мөрдөн ажилласан байна. | Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны ХЭГ/595 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу “Шуур” ажиллагааны хэрэгжилтийг хангаж |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны ХЭГ/595 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр өгсөн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, дүнг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, | | төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй томилогдсон нэг албан хаагчийг 2023 оны 04 сарын 01-нээс чөлөөлсөн .<br>Мөн Хэнтий аймагт Төрийн албаны зөвлөлөөс 2023 оны 06 дугаар сарын 12 – 13ны өдөр “Шүүр” ажиллагаатай холбоотой хяналт шалгалт хийгдсэн. Шалгалтаар төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл, хүний нөөцийн программд оруулсан мэдээлэлийн бүрдэл, 2019 оноос хойш тушаал шийдвэрт хяналт шалгалт хийсэн бөгөөд “Шүүр” ажиллагаатай холбоотой зөрчил илрээгүй болно.<br>Санхүү Бүртгэлийн тасгийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч, Хяналт шалгалт дотоод аудитын тасгийн дарга, дотоод аудитор, Баянхутаг сумын нийгмийн даатгалын байцаагчын албан тушаалд ажиллаж байсан 3 албан хаагчыг 2023 оны 11 дүгээр сарын 16-нд тусгай шалгалтанд хамруулж зөвлөмжийг биелүүлсэн. |
| | | 4.2. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг оруулж, хэрэгжилтэд хяналт тавих; | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байх;<br>- Тайлагнасан байх; | Албан хаагчдын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах зорилтод:<br>- Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийгмийн даатгалын байгууллагын ёс зүйн дүрэмийг мөрдлөг болгох<br>- Ашиг сонирхлын зөрчлөөс өөрийгөө урьдчилан сэргийлж ажиллах арга хэмжээг оруулж өгсөн.<br>Хэрэгжилтийг гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд ажил дүгнэх комисс хяналт тавьж дүгнэж ажиллаж байна. |
| | | 4.3. Нийгмийн даатгалын салбарт хийгдсэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газрын цахим хуудас, фэйсбүүк, болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр түгээх ажлыг зохион байгуулах; | - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байх | hentii.ndaatgal.mn вэб сайтанд танилцуулга мэдээлэл, видёо мэдээлэл, зурган мэдээлэл, гарын авлаг, тухай бүр зохион байгуулсан мэдээ мэдээллийг бүрэн оруулж хэвийн ажиллуулж байна.<br>2023.05.26 ны 01/1132 тоот албан бичиг Засгийн газрын 2022 оны 352 ддугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээлийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасны дагуу Цахим хуудсанд байршуулах нээлттэй мэдээллийн жагсаалтын дагуу мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан. |
| | | 4.4. Дотоод нөөц бололцоог ашиглан албан хаагчиддаа сургалт зохион байгуулсан байх: | - Албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулсан байх; | Нийтдээ 5 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 93 албан хаагч хамрагдсан.<br>- 2023-02-02-нд “Авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” сургалт 14 албан хаагч хамрагдсан. Сургалтыг АТГ-ын ахлах комиссар Л.Нарантуяа явуулсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Тайланд нотломжийг хавсаргасан байх. | - “ Авлига, ашиг сонирхлын зөрчил” сэдвээр 2023-03-16нд Хэнтий аймгийн Прокурорын газартай хамтран ахлах прокурор Б.Буяндэлгэр, ахлах прокурор М.Отгонбаатар нар танхимаар 37 албан хаагч хамрагдсан.<br>- “Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалт 2023-03-29-нд НДЕГ-с зохион байгуулсан бөгөөд 3 албан хаагч хамрагдсан.<br>- Орон нутагт нийтлэг гарч буй авлига, ашиг сонирхлын зөрчилд анхаарах асуудалын талаар АЗДТГ-с 2023.06.15нд сургалт хийж 4 албан хаагч хамрагдсан.<br>- Төрийн албаны ёс зүйн тухай хууль<br>- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь<br>- Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчийн харилцаа ба хандлага, кэйсүүд 2023.10.16нд НДЕГ-ын ТГ-ын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Мө.Гэрэлмаа танхимаар явуулж 35 албан хаагч хамрагдсан. |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ЭБАТ А.ОКТЯБРЬ.